



ҮНДЭСНИЙ
ХУВЬЧЛАЛЫН
САН

2026

ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

2026

Хагас жилийн
тайлан

MSE:XOC

ЭРХЭМ ХҮНДЭТ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНАА

Оны эхний хагаст Монголын хөрөнгийн зах зээл тогтвортой, эерэг чиг хандлагаараа онцлог байлаа. Гадаад орчны тодорхойгүй байдал бага зэрэг буурч, дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал харьцангуй тогтвортой болсноор дотоодын хөрөнгө оруулагчид урт хугацааны, тооцоотой шийдвэр гаргах хандлага руу шилжсэн нь тод ажиглагдлаа.

Энэ хугацаанд Үндэсний Хувьчлалын Сан өмнөх жилээс эхлүүлсэн бодлогынхоо дагуу гадаадын үнэт цаасны зах зээлд оролцох хувийг багцдаа үе шаттайгаар нэмэгдүүлсээр байна. Энэ нь эрсдэлийг улс орон, валют, салбарын хувьд илүү тэлж хуваарилах, өргөн боломж бүхий шинэ зах зээлүүдэд нэвтрэх, өгөөжийн олон эх үүсвэртэй болох стратегийн зорилготой хэрэгжиж байна. Дотоодын томоохон, ач холбогдолтой компаниудыг дэмжих уламжлалт бодлогоо орхилгүй үргэлжлүүлж буй бол гадаад хөрөнгө оруулалт нь сангийн ерөнхий тогтвортой байдлыг бэхжүүлж, зах зээлийн савлагаанаас хамгаалах нэмэлт хамгаалалт болж байна.

Хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалт нь өнөөг хүртэл богино хугацааны үнийн хэлбэлзэлд бус, компанийн бодит үнэлгээ, ашигт ажиллагаа, инновацийн чадавх, өсөх боломж зэрэг гүнзгий шинжилгээнд тулгуурлаж байна. Мөн эрсдэлийн удирдлагын тогтолцоог олон улсын жишигт улам ойртуулах, валют болон зах зээлийн эрсдэлийн хяналтыг чангатгах ажил тасралтгүй хийгдэж байна. Ингэснээр гадаад зах зээлд оролцох үйл ажиллагаа нь сангийн урт хугацааны стратегитай нийцсэн, хяналттай, шат дараалсан байдлаар үргэлжилж байна.

Цаашдын үйл ажиллагаанд зах зээлийн өөрчлөлтөд уян хатан хандаж, хөрөнгө оруулалтын боломжийг бодит үнэлгээ, эрсдэлийн зохистой удирдлагад тулгуурлан ашиглахын зэрэгцээ хөрөнгө оруулагчдын урт хугацааны өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогоо тууштай хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Сангийн менежер

У.Сүхдарь

ТАНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ГҮЙЦЭТГЭЛ

- Үндэсний Хувьчлалын Сан 2020 оны 10 дугаар сард хамтын хөрөнгө оруулалтын сангийн зохион байгуулалтын хэлбэрээр үүсгэн байгуулагдсан бөгөөд байгуулагдах үеэс эхлэн Монгол Улсын хөрөнгийн зах зээлд иргэдийн оролцоог өргөжүүлэх, төрийн өмчит үйлдвэрийн газруудыг хувьчлах үйл явцад олон нийтийг татан оролцуулах стратегийн зорилтыг тавьж ажилласаар ирсэн. Сангийн үйл ажиллагааны зургаан жил гаруй хугацаанд дэлхий нийтийг хамарсан цар тахал, геополитикийн хурцадмал байдал, зах зээлийн эрс тэс хэлбэлзэл зэрэг олон сорилт бэрхшээл тулгарсан боловч байгууллага өөрийн стратегийн чиг баримжаагаа алдалгүй, мэргэжлийн түвшний удирдлага, нягт нямбай төлөвлөлтөд суурилан тасралтгүй хөгжиж ирлээ. Зах зээлийн мөчлөгийн харилцан адилгүй үе шатуудыг даван туулахдаа Сан нь агшин зуурын өгөөжид бус, урт хугацааны үнэ цэнийг бий болгоход чиглэсэн бодлого баримталж, эрсдэлийн удирдлагыг чанд мөрдсөөр ирсэн нь тогтвортой өсөлтийн үндэс суурийг тавьж, хөрөнгө оруулагчдын итгэлийг улам бэхжүүлсэн үндсэн хүчин зүйл болсон юм.
- 2026 оны эхний хагасын гол үзүүлэлт бол сангийн хөрөнгө оруулалтын бодлогод хийсэн бүтцийн шинэчлэл юм. Энэ хугацаанд гадаадын хөрөнгийн зах зээлд оролцох стратегия идэвхжүүлж, олон улсын хөрөнгийн бирж дээр арилжаалагддаг хувьцааны эзлэх хувийг нийт багцын 15 хувь хүртэл нэмэгдүүлсэн бөгөөд энэ нь дунд, урт хугацааны чиг баримжаа бүхий бодлогын шинэчлэлийн үр дүн юм. Санхүүгийн үзүүлэлтийн хувьд 06 сарын 30-ны байдлаар сангийн цэвэр хөрөнгө ₮7.32 тэрбумд хүрсэн нь анхны байгуулалтын үеийнхээс 46.4 хувиар өссөн үзүүлэлт юм. Энэхүү өсөлтийг сан хөрөнгө оруулалтын бодлогоо тууштай, сахилга баттай хэрэгжүүлсний шууд илрэл гэж үзэж болно. Гэвч нэгж эрхэд ногдох цэвэр хөрөнгийн үнэлгээ өөр чиг хандлага үзүүлж, оны эхэнтэй харьцуулахад ₮145.9 болж, 3.4 хувиар буурчээ. Энэ зөрүүтэй үзүүлэлт нь зах зээлийн тогтворгүй нөхцөл, гадаад дотоод орчны эрсдэл бүрэн алга болоогүйтэй холбоотой боловч сангийн эрсдэлийн хяналт, судалгаанд суурилсан хөрөнгө оруулалтын арга барил нь нийт өгөөжийг тогтвортой байлгахад чиглэгдсэн хэвээр байгааг харуулж байна.

Хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн өгөөжийн харьцуулалт

	2021	2022	2023	2024	2025	2026H2
Үндэсний Хувьчлалын Сангийн өгөөж	91.2%	-24.4%	-10.63%	7.21%	12.4%	-3.4%
ТОП-20-ийн өгөөж	130%	-15.4%	10.31%	23.79%	7.9%	-2.7%
Хадгаламжийн хүү	~9%	10.3%	12.00%	11.77%	12.4%	13.2%

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж, Монголбанк

ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САНГИЙН ТОВЧ ГҮЙЦЭТГЭЛ

Тикэр
ХОС

Гаргасан нэгж эрх
50 сая ширхэг

Нэгж эрх эзэмшигчийн тоо
7,102

Нэгж эрхийн хаалтын ханш
₮86.46

Зах зээлийн үнэлгээ
₮4.32 тэрбум

Хагас жилийн арилжааны эргэлт
₮105.3 сая

Нэгж эрхийн NAV
₮145.9

Нийт цэвэр хөрөнгө NAV
₮7.32 тэрбум

ТУЗ ГИШҮҮДИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



Хүрэлбаатарын Билгүүн

**“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” хамтын ХОС-ийн
ТУЗ-ийн дарга**

Мэргэжил: Санхүү, эдийн засаг

Албан тушаал: “Ард Секюритиз ҮЦК” ХХК-ийн
Гүйцэтгэх захирал



Галбадрахын Цогбадрах

**“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” хамтын ХОС-ийн
ТУЗ-ийн ердийн гишүүн**

Мэргэжил: Эдийн засагч, санхүүч

Албан тушаал: “Ард Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн
гишүүн



Чадраабалын Даваасамбуу

**“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” хамтын ХОС-ийн
ТУЗ-ийн ердийн гишүүн**

Мэргэжил: Санхүү, эдийн засаг

Албан тушаал: “Ард Менежмент” ХХК-ийн
Гүйцэтгэх захирал



Пүрэвийн Баянсан

**“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” ХХК-ийн ТУЗ-
ийн хараат бус гишүүн**

Мэргэжил: Бизнесийн удирдлага

Албан тушаал: , МУИС, Санхүүгийн тэнхимийн
ахлах багш



Батхүү Ариунболд

**“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” хамтын ХОС-ийн
ТУЗ-ийн хараат бус гишүүн**

Мэргэжил: Санхүү, эдийн засаг

Албан тушаал: “Интергрупп Интернэйшнл ХХК”
Санхүү эрхэлсэн захирал

“Ард Менежмент” ХХК-ийн баг “Үндэсний Хувьчлалын Сан” хамтын ХОС-ийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэх, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах зэрэг гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг хэрэгжүүлж ажилладаг.



Угтахбаяр Сүхдарь

Мэргэжил: Санхүү, Хөрөнгө оруулалт

Албан тушаал: “Ард Менежмент” ХХК-ийн сангийн
менежер

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО

Сан нь хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд тооцоо судалгаа хийсний үндсэн дээр хөрөнгө оруулалт хийдэг бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хорооны шинэчилсэн журмын дагуу Сангийн нийт хөрөнгийн 80-аас доошгүй хувиар дотоод болон гадаадын хөрөнгийн зах зээлд бүртгэлтэй хувьцаат компанийн хувьцаанд хөрөнгө оруулалт хийж ажилладаг. Ингэхдээ компанийн суурь шинжилгээ, зах зээлийн судалгаа зэргийг багтаасан мэргэжлийн судалгаа шинжилгээнд үндэслэн хөрөнгө оруулалт хийдэг билээ.


НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

2025 оны эцсийн байдлаар Үндэсний Хувьчлалын Сангийн нэгж эрх эзэмшигчдийн тоо 7,100 байсан бол оны 2026 оны эхний хагас жилийн байдлаар 7,102-д хүрч 0.03%-аар өссөн байна. Нэгж эрх эзэмшигчдийн тоо тогтвортойгоор өсөж байгааг харвал сангийн үйл ажиллагаа хэвийн байгаа болон хөрөнгө оруулалтын сангийн эрэлт хэрэгцээ буураагүй байгааг харж болж байна.

Нэгж эрх эзэмшигч	Нэгж эрхийн тоо	Хувь
АРД ДААТГАЛ ХК	5,229,786.00	10.46%
АРДЫН ТЭТГЭВРИЙН ДАНС ХХК	3,762,392.00	7.52%
ТУЛГА	2,999,610.00	6.00%
АРД МЕНЕЖМЕНТ ҮЦК ХХК	2,507,445.00	5.01%
М СИ ЭС ИНВЕСТМЕНТ ХХК	2,500,000.00	5.00%
АРД КРЕДИТ ББСБ ХК	1,558,998.00	3.12%
БОГД БАНК ХК	1,371,500.00	2.74%
МАНДАХБАЯР	1,000,000.00	2.00%
НАРАНБАТ	1,000,000.00	2.00%
ЦЭРЭНДОЛГОР	807,141.00	1.61%
Бусад 7,092	27,263,128	54.53%
Нийт	50,000,000	100.00%

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ


ХОС нь 2026 он эхний хагас жилд гадаад улсын бирж дээр бүртгэлтэй хувьцаанд түлхүү хөрөнгө оруулалт хийж ажиллалаа. Цэвэр хөрөнгийн үнэлгээ 2026 оны эхний хагаст 7.32 тэрбум төгрөгт хүрч 3.4%-иар, зах зээлийн үнэлгээ нь 4.32 тэрбум төгрөгт хүрч 11.2%-иар тус тус унасан байна. Харин үүсгэн байгуулагдсан цагаас хойш цэвэр хөрөнгийн үнэлгээ 46.0%-аар өсөөд байна.



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж


	Зах зээлийн ханш	NAV(Цэвэр хөрөнгийн үнэ)
2026/06/30	86.4	145.9
Оны эхнээс %	-11.2%	-3.4%
Сан нээгдсэнээс хойш	-13.5%	45.9%
2026 оны доод дээд	80.1-92.7	130.4-145.9

Тайлант хугацааны туршид сангийн хөрөнгийн бүтцийн өөрчлөлт



Эх сурвалж: Ард менежмент ХХК

Тайлант хугацааны эцэс дэх сангийн хөрөнгийн задаргаа (Зах зээлийн үнэлгээгээр болон өртгийн аргаар)




Эх сурвалж: Ард менежмент ХХК

ХОС нь хөрөнгө оруулалтын бодлого болон зохицуулагч байгууллагаас тогтоосон хөрөнгө оруулалтын харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хөрөнгийн өртгийн аргаар тооцон мөрдөж ажилладаг бөгөөд тайлант хугацаанд холбогдох бүх шаардлагыг бүрэн ханган ажилласан. Сангийн хөрөнгө оруулалтын үндсэн зорилго нь урт хугацаанд тогтвортой өгөөж бий болгоход чиглэдэг. Иймд зах зээлийн богино хугацааны үнийн хэлбэлзэлд үндэслэн багцыг ойр ойрхон дахин тэнцвэржүүлэх нь энэхүү стратегитай нийцэхгүй гэж үздэг. Шалтгаан нь багцад байгаа өсөлттэй хувьцааны хувийн жинг бууруулахгүй байх, уналттай хувьцааны хувийн жинг өсгөхгүй байх нь хөрөнгө оруулалтын зөв бодлого гэж үздэгт оршино. Иймээс энэхүү бодлого нь урт хугацааны хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх, багцын үр ашгийг хадгалахад чиглэсэн оновчтой арга барил гэж Сан үзэж байна.

ХОС-ийн хөрөнгө оруулалтын багцын үндсэн хэсгийг Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй нээлттэй хувьцаат компаниудын үнэт цаас бүрдүүлдэг бөгөөд тайлант хугацааны эцэст нийт багцын ойролцоогоор 72 хувийг эзэлж байна. Тайлант хугацаанд дотоод, гадаадын зах зээлийн нөхцөл байдал болон хөрөнгө оруулалтын үнэлгээнд үндэслэн зарим хувьцааны хөрөнгө оруулалтыг бууруулж, ирээдүйд өсөлтийн өндөр боломжтой гэж үнэлэгдсэн үнэт цаасуудад хөрөнгийг дахин байршуулах замаар багцын бүтцийг оновчлон шинэчилж ажилласан. Энэхүү өөрчлөлт нь Сангийн урт хугацааны хөрөнгө оруулалтын бодлого, эрсдэлийн удирдлага болон өгөөжийг нэмэгдүүлэх зорилготой бүрэн нийцэж байна.

2026 оны 06 дугаар сарын 30-ний байдлаар ХОС-ийн хувьцааны багцад нийт 32 хувьцаа байгаа бөгөөд үүнээс 23 нь дотоодын хувьцаа, 9 нь гадаад хувьцаа байна. Салбараар нь харвал санхүүгийн 11, өргөн хэрэглээний 4, түүхий эдийн 4, аж үйлдвэрийн 4, тогтмол бус хэрэглээний 4, технологийн 2, харилцаа холбооны 1, сэргээгдэх эрчим хүчний салбарын 2 хувьцаануудаас багц бүрджээ.

Хувьцааны багц, эдийн засгийн салбараар (Зах зээлийн үнэлгээгээр болон өртгийн аргаар, нийт хөрөнгийн багцад эзлэх хэмжээ %)




Эх сурвалж: Ард менежмент ХХК

САНГИЙН ЗАРДАЛ

Тайлан хугацаанд сангийн нийт хөрөнгийн өдрийн дундаж үлдэгдэл нь 6,978 сая төгрөг байсан бөгөөд зардлын нийт дүн нь 162 сая төгрөг болсон байна. Нийт хөрөнгийн үнэлгээнээс тооцсон нийт зардлын харьцаа нь 2026 онд 2.20% байна. Бусад зардалд нэгж эрх эзэмшигчдийн хурал зохион байгуулах, мэргэжлийн ажил үйлчилгээний зардал зэрэг орсон байна.

Зардлын задаргаа(Сая төгрөгөөр)




Эх сурвалж: Ард менежмент ХХК

САНГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Тайлант хугацааны эцэст зах зээлийн үнэлгээгээр тооцвол багцын 90%-ийг эрсдэл өндөртэй хөрөнгө буюу хувьцаа эзэлж байгаа бол үлдсэн хэмжээг эрсдэл бага, тогтмол өгөөж бүхий хөрөнгүүд эзэлж байна.

Сангийн өдөр бүрийн цэвэр хөрөнгийн үнэлгээний (NAV) тоо мэдээнд тулгуурлан шинжилж үзвэл, эрсдэлийн үзүүлэлтүүд нь дараах байдалтай байна.

Өдрийн NAV хөдөлгөөний тархалт




Эх сурвалж: Ард менежмент ХХК

Хөрөнгө Оруулагч Үндэстэн сангийн цэвэр хөрөнгийн үнэлгээний 1,403 өдрийн мэдээлэлд тулгуурлан эрсдэлийн үзүүлэлтийг тооцоолбол дээрх байдалтай байна.

Хөрөнгө оруулалтын сангийн цэвэр хөрөнгийн үнэлгээний өдрийн стандарт хазайлт нь өндөр байх тусам хөрөнгө оруулагчид өндөр эрсдэл хүлээж байгааг илэрхийлдэг. Олон улсад өдрийн стандарт хазайлтыг 2%-аас дээш байвал эрсдэл өндөр, 1%-аас бага байвал эрсдэл бага гэж үздэг бөгөөд Үндэсний Хувьчлалын сангийн хувьд өдрийн стандарт хазайлт 1.80% байна.

НЭГЖ ЭРХИЙН АРИЛЖАА

Үндэсний Хувьчлалын Сан нь хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сан буюу гаргасан нэгж эрхээ эргүүлэн худалдан авах үүрэг хүлээдэггүй сан юм. Хөрөнгө оруулагчид нэгж эрхээ Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан өөр хоорондоо арилжаалах боломжтой байдаг бөгөөд сангийн хөрвөх чадвар сайн байх нь зах зээлийн ханш зөв тогтох үндэс болдог. ХОС-ийн нэгж эрхийн арилжааны эргэлт 2026 оны эхний хагаст ₮173.3 сая байгаа ба нийт 1.29 сая ширхэг нэгж эрх арилжаалагдсан ба энэ нь сангийн 2.48 хувь гар сэлгэсэн байна.



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИЙН ТАЙЛАН

Ард Менежмент ХХК (цаашид “Ард Менежмент” гэх) нь өндөр өгөөжтэй, ирээдүйд хурдтай өсөх төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилготой хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, удирдах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Ард Менежмент нь 2011 онд үүсгэн байгуулагдаж, 2016 онд Санхүүгийн Зохицуулах Хорооноос тусгай зөвшөөрөл авснаар хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх болсон.

Ард Менежмент нь 2020 оны 6 дугаар сарын 2-ны өдөр ХОС-той байгуулсан №20/14 тоот Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний дагуу Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан явуулж байна.

2026 оны эхний хагаст Ард Менежментээс ХОС-д гэрээний дагуу үзүүлсэн ажил үйлчилгээг тоймлон харуулбал:

Хөрөнгө итгэмжлэн удирдах

- ХОС-ийн хувьд 2026 оны 06-р сарын 30-ний байдлаар 7.32 тэрбум төгрөгт хүрч 3.4%-иар, зах зээлийн үнэлгээ нь 4.32 тэрбум төгрөгт хүрч 11.2%-иар тус тус унасан байна бол үүсгэн байгуулагдсан цагаас хойш 45.9 хувийн өсөлтийг үзүүлсэн байна.
- Хөрөнгө оруулалтын багцыг удирдах. ХОС-ийн хувьд 2026 оны 06-р сарын 30-ний байдлаар 26 сая төгрөгийн хүүгийн орлого, 246 сая төгрөгийн ногдол ашгийн орлого тус тус олсон
- Хөрөнгө оруулалтын судалгаа, шинжилгээг
- Хөрөнгө оруулалтын судалгаа, шинжилгээг тогтмол хийж, хөрөнгө оруулалтын боломжийг эрэлхийлэх.
- Хөрөнгө оруулалтын нарийвчилсан төлөвлөгөөг батлуулж, сангийн менежерийн эрхийн хүрээнд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах, зөвшөөрөгдсөн хэмжээнээс өндөр дүнтэй хэлцлүүдийг ТУЗ-н шийдвэрээр гүйцэтгэж байна.

ХОС-ийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах

- ХОС-ийн хөрөнгийн бүртгэлийг хөтлөх, хадгалах, хуульд заасан хугацаанд холбогдох төрийн байгууллагуудад санхүүгийн тайланг гаргаж хүргүүлэв.
- ХОС-ийн тайлан мэдээнүүдийг гаргаж, тайлагнахтай холбоотой Голомт Банкны кастодиан банкны газар, МХБ, СЗХ-той хамтран ажиллаж, МХБ болон Ард Менежментийн цахим сайтуудад Сангийн нэгж эрхийн арилжаа, хөрөнгө оруулалтын талаар тогтмол мэдээг хүргэв.
- ХОС-ийн багц дахь хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн арилжааны захиалга хийх, төлбөр тооцоо төлөх, кастодиантай мэдээлэл солилцох ажлыг тогтмол гүйцэтгэж байна.
- Сангийн үйл ажиллагааг зохицуулахад шаардлагатай журам, заавар гаргаж, түүнийг боловсронгуй болгох, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

САНГИЙН МЕНЕЖЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Үндэсний Хувьчлалын Сангийн менежер У.Сүхдарь нь хөрөнгө оруулалтын сантай холбоотой хууль, дүрэм, журмын хүрээнд сангийн хөрөнгийг удирдаж, өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан ажиллалаа. Үндэсний Хувьчлалын Сангийн хувьд хөрөнгө оруулалтын багцыг удирдах, сангийн өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор нийт 1,198.0 сая төгрөгийн нийт 168 хэлцэл хийгдсэн ба 15 хувьцаагаар дамжуулан хийлээ.

Сангийн менежерийн үндсэн ажлыг хөрөнгө оруулалтын болон үйл ажиллагааны гэж хоёр хувааж авч үзэж болох бөгөөд дараах ажлууд тогтмол болон тухай бүр хийгдсэн байна.

Сангийн хөрөнгийн удирдлагатай холбоотой ажлууд:

- Хөрөнгө оруулалтын багцыг удирдах. ХОС нь урт хугацааны хөрөнгө оруулалтууд хийдэг ба хэтэрхий өндөр үнэлэгдсэн тодорхой хэдэн хувьцаануудаас гарсан ба өсөлт үзүүлэх боломжтой дунд хугацааны хөрөнгө оруулалтууд хийж ажиллалаа.
- Хөрөнгө оруулалтын судалгаа, шинжилгээг тогтмол хийж, хөрөнгө оруулалтын боломжийг эрэлхийлэх.
- Хөрөнгө оруулалтын нарийвчилсан төлөвлөгөөг батлуулж, сангийн менежерийн эрхийн хүрээнд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах, зөвшөөрөгдсөн хэмжээнээс өндөр дүнтэй хэлцлүүдийг ТУЗ-ийн шийдвэрээр гүйцэтгэх.

Сангийн үйл ажиллагаатай холбоотой ажлууд:

- Сангийн үнэ ханшийн мэдээллийг өдөр бүр олон нийтэд хүргэх.
- Улирал бүр ТУЗ-ийн хурлыг хуралдуулж сангийн үйл ажиллагаа, үр дүнг танилцуулах, шаардлагатай шийдвэрүүдийг гаргуулах.
- Хагас жил бүр Earning Call хийж сангийн үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээллийг олон нийтэд хүргэх.
- Зохицуулагч байгууллагуудтай харилцах.
- Кастодиан банканд сангийн хөрөнгийг хадгалуулах, тайлан мэдээний үнэн зөв байдалд хяналт тавих.
- Сангийн хагас жилийн болон бүтэн жилийн тайланг бэлтгэж олон нийт болон зохицуулах байгууллагад хүргүүлэх.
- СЗХ-ны хяналт шалгалт болон хөндлөнгийн аудит хийлгэх, холбогдох материалыг бүрдүүлэх, үүрэг даалгаврыг биелүүлэх.

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

Нийт хөрөнгийн хувьд 7,180 сая төгрөгийн хөрөнгөтэй, цэвэр хөрөнгө 6,782 сая төгрөгт хүрсэн бөгөөд 2025 онтой харьцуулахад хөрөнгө 4.95%, цэвэр хөрөнгийн дүн 7.17%-ийн уналтыг тус тус үзүүлсэн байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Сая төгрөг


Үзүүлэлт	2025 Q4	2026 Q2
Нийт хөрөнгө	7,554	7,180
Мөнгө	209	384
Санхүүгийн хөрөнгө /Бодит/	7,306	6,782
Авлага	26	1
Хойшлогдсон татварын хөрөнгө	13	13
Нийт өр төлбөр	7	7
Дансны өглөг	1	1
Хойшлогдсон татварын өр	6	6
Эздийн өмчийн дүн	7,547	7,173
Өмч	5,000	5,000
Хуримтлагдсан ашиг	2,547	2,173

ОРЛОГЫН ТАЙЛАН

Сая төгрөг

Үзүүлэлт	2025 Q4	2026 Q2
Хүүгийн орлого	38	26
Ногдол ашгийн орлого	235	246
Бодит үнэ цэнийн өсөлтийн олз	818	(443)
Нийт ашиг (алдагдал)	1,091	(171)
ХОМК-ийн үйлчилгээний зардал	(148)	(95)
Кастодианы үйлчилгээний зардал	(19)	(14)
Бусад зардал	(129)	(93)
Нийт үйл ажиллагааны зардал	(296)	(202)
Татварын өмнөх ашиг	795	(373)
Хойшлогдсон татварын зардал	(4)	(1)
Тайлант үеийн цэвэр ашиг	791	(374)


МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ



- Зэсийн экспортын өсөлт үргэлжилж, нүүрсний биет экспортийн хэмжээ түүхэн дээд түвшинд байгаагийн зэрэгцээ өмнөх жилийн бага өсөлттэй байсан суурь нөлөөгөөр уул уурхай, түүнийг дагасан тээврийн салбар эдийн засгийн өсөлтийн дийлэнх хэсгийг бүрдүүллээ.
- Малын зүй бус хорогдол өсөлттэй байснаас гадна төл бойжилтийн өсөлт саарсан нь хөдөө аж ахуйн салбарын өсөлтийг бууруулав.
- Голлох хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлт буурч, үнийн түвшин өссөн нь боловсруулах салбарын өсөлтөд сөргөөр нөлөөлсөн бол эрчим хүчний салбарын өсөлт үргэлжилсэн хэвээр байна.
- Бодит цалин буурч, өрхийн орлогын өсөлт саарснаас гадна хэрэглээний зээлийн өсөлт саарч байгаа нь дотоод эдийн засгийн идэвхжилийг бууруулж, худалдаа, үйлчилгээний өсөлтийг удаашруулсан хэвээр байна.

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ



Инфляц өндөр түвшинд хэвээр байна


- Тариалангийн бүс нутгуудаар гантай байсан нь хүнсний бүтээгдэхүүний үнийг нэмэгдүүлсэн
- Мах, махан бүтээгдэхүүний үнэ улирлын тогтсон онцлогийн эсрэг чиглэлд өсөв
- Өрхийн цахилгааны суурь үнийн нөлөө арилснаар төрийн зохицуулалттай үйлчилгээний инфляц буурсан



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

МХБ-н арилжаа, Зах зээлийн үнэлгээ / 2021-2026 /



2026 оны эхний хагас жилд нийт 123 удаагийн үнэт цаасны арилжаагаар 800 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж нийт арилжааны дүн өмнөх оноос 1.4 дахин нэмэгдэж, хоёрдогч зах зээлийн арилжаа 2.6 хувиар өссөн байна.

МХБ-н арилжааг арилжааны төрлөөр авч үзвэл нийт арилжааны 17.5 хувийг хувьцааны арилжаа, 0.2 хувийг хөрөнгө оруулалтын сангийн арилжаа, 66.4 хувийг бонд, хбүц-ийн арилжаа, 16 хувийг засгийн газрын үнэт цаасны арилжаа бүрдүүлж байна.

Тайлант хугацаанд хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 139.9 тэрбум төгрөгийн хувьцаа арилжигдсанаас 51 хувь буюу 71.6 тэрбум төгрөгийн гүйлгээг энгийн арилжаа, 49 хувь буюу 68.3 тэрбум төгрөгийн гүйлгээг багцын арилжаа тус тус эзэлж байна.


2026 оны эхний хагас жилд сарын дундаж хоёрдогч арилжааны дүн 23 тэрбум төгрөг болж арилжааны идэвх суларсан бөгөөд зах зээлийн үнэлгээ жилийн эцсээс 1.2 хувь буурч 13.6 их наяд төгрөгт хүрлээ.

Улаанбаатар үнэт цаасны бирж дээр 2026 оны эхний хагас жилд нийт тэрбум 10.9 тэрбум төгрөгийн арилжаа явагдаж арилжааны дүн өмнөх онд мөн үеэс 70% буурсан байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

Биржийн бус зах зээлийн анхдагч арилжааны дүн, тэрбум.төгрөг /2023-2025/



Биржийн бус зах зээл нь үнэт цаас гаргагчийн цаг хугацаа, зардлыг хэмнэж, богино хугацаанд санхүүжилт татах нэгэн талбар бөгөөд компаниуд хэрэгтэй санхүүжилтээ татахын тулд хөрөнгийн зах зээлийг чиглэх хандлага нь нэмэгдсээр байна.

2026 оны эхний хагаст ББЗЗ-д төгрөгийн бондоор 1.4 их наяд төгрөг, ам.долларын бондоор 26.9 сая ам.долларын хөрөнгө татан төвлөрүүлсэн байна. Харин 2021 онд ББЗЗ-ийн үйл ажиллагаа анх эхэлснээс хойш компаниудын нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ 6.9 их наяд төгрөгт хүрчээ.

Өнгөрсөн оны эцэст нийт гаргасан бондуудын 39 хувийг бүрдүүлж байсан санхүүгийн салбарын компаниудын эзлэх хувь 2026 оны эхний хагаст буурч, бодит эдийн засгийн салбарын компаниуд өрийн хэрэгслийн зах зээлд илүү идэвхтэй оролцож эхэлсэн байна.

Дийлэнх бонд 1-2 жилийн хугацаатай гарсан ба хүүгийн түвшин дунджаар 19.8 хувьтай байна.

Эх сурвалж: МҮЦАЭХ

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

2026

Хагас жилийн
тайлан

MSE:XOC